

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар: 04

Улаанбаатар хот

**Гүйцэтгэх удирдлагад үүрэг
даалгавар өгөх тухай**

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1, 21.2.9, Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.14, 3.3.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн санхүүгийн эрсдэл, эрсдэл даах чадварт актуар тооцоолол хийсэн хөндлөнгийн актуарчийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн “Үндэсний давхар даатгал” ХК-ийн гүйцэтгэх удирдлагад өгөх хугацаатай үүрэг даалгаврыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг бүрэн хангаж, биелэлтийг заасан хугацаанд багтаан Төлөөлөн удирдах зөвлөлд ирүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Ц.Дашдондог), Эрсдэлийн хороо (Д.Нямрагчаа), Дотоод аудитын алба (Д.Дуулал)-нд тус тус даалгасугай.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ